

Гадаад иргэдийн оролцоотой хамтын нийгмийг биелүүлэх төлөвлөгөө(2023 онд хэсэгчлэн шинэчлэн найруулсан) (Тойм)

2022 оны 6-р сард бид Япон улсын зорьж буй гадаадын иргэдийн оролцоотой хамтын нийгмийн хэтийн төлөв, түүнийг хэрэгжүүлэх дунд болон урт хугацаан дахь шийдвэрлэх асуудлууд, тодорхой арга хэмжээнүүдийг тусгасан төлөвлөгөө гаргахаар шийдсэн билээ. Одоо тус арга хэмжээг тууштай хэрэгжүүлэх зорилгоор хэрэгжилтийн байдалд мэргэжилтнүүдийн дүгнэлтийг сонссоны үндсэн дээр хяналт шалгалт хийж, арга хэмжээнүүдийг дахин дүгнэж байна.

1 Гадаад иргэний оролцоотой хамтын нийгмийн хүсэмжит байдал (3 дүр төрөх)

Аюулгүй, тайван нийгэм

Ирээдүйн Японыг хамтран бүтээн байгуулах хамт олны нэг гэдэг утгаар гадаад иргэдийг хүлээн авдаг, бүх хүн аюулгүй, тайван амьдарч чаддаг нийгэм

Олон янз байдалтай идэвхтэй нийгэм

Янз бүрийн угсаа гаралтай гадаад иргэд болон бусдаас бүрдсэн хүмүүс нийгэмд оролцож, өөрсдийн чадавхыг бүрэн дүүрэн нээдэг, олон янзын эрч хүчтэй нийгэм

Хувь хүнийг хүндэтгэн хүний эрхийг дээдэлдэг нийгэм

Гадна дотнын иргэдээс бүрдсэн хүмүүс харилцан хувь хүнийг хүндэтгэн хүний эрхийг дээдэлж, ялгаварлан гадуурхалгүйгээр амьдарч чаддаг нийгэм

2 Дунд, урт хугацаанд шийдвэрлэх ёстой асуудлууд (4 үндсэн зорилго)

1. Саадгүй харилцан ойлголцож, нийгэмд оролцох идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн япон хэлний сургалт зэрэг ажлууд
2. Гадаад иргэдэд мэдээлэл түгээх, тэдэнд зориулсан зөвлөгөө өгөх тогтолцоог бэхжүүлэх
3. Амьдралын үе шат, мөчлөгт тохирсон дэмжлэг туслалцаа үзүүлэх
4. Хамтын нийгмийн суурь тогтцыг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ

3 Үндсэн зорилгоо биелүүлэх гол арга хэмжээнүүд

1 Саадгүй харилцан ойлголцож, нийгэмд оролцох идэвхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн япон хэлний сургалт зэрэг ажлууд

- Нийслэл, мужуудын япон хэлний сургалтыг эрчимжүүлэхийн тулд цогц байдлаар орчин бүрдүүлэх ажлыг баттай хөгжүүлэх бөгөөд хот, тосгоны засаг захиргаа нь нийслэл, мужуудтай хамтран ажиллаж япон хэлний сургалт болон бусад үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх [БШЯ] «1»
- “Япон хэлний боловсролын лавлах хүрээ”-д заагдсан сургалтын агуулга, түвшин тогтоох шалгуур зэрэгт нийцүүлж, боловсролын салбарчилсан загвар хөтөлбөрийг боловсруулах [БШЯ] «3»
- Амьдралын чиг баримжаа олгох (Японд амьдрахад хэрэгтэй суурь мэдлэг, анхан шатны япон хэлний сургалт) дүрс бичлэг бэлтгэх, ашиглах замаар нийгмийн ёс журамтай танилцах орчин бүрдүүлэх (Японд ирэхээс өмнө бас) [ХЗЯ] «6»
- Амьдралд тохиолдох янз бүрийн хэрэгцээнд нийцсэн япон хэлийг эзэмшүүлэх ICT сурах материалыг бэлтгэх, хангах [БШЯ] «8»
- Гадаадад байхад нь япон хэл суралцах боломжоор хангаж өгснөөр Японд ирэхээс өмнө саадгүй харилцан ойлголцох чадамжтай болгох [ГХЯ] «9»
- Япон хэлний боловсролын байгууллагуудыг магадлан итгэмжлэх, япон хэлээр багшлах эрхийн зөвшөөрөл олгох тогтолцоо бүрдүүлэх [БШЯ] «11»

2 Гадаад иргэдэд мэдээлэл түгээх, тэдэнд зориулсан зөвлөгөө өгөх тогтолцоог бэхжүүлэх

- “Амьдрах, хөдөлмөр эрхлэх гарын авлага” болон “Гадаад иргэд амьдрахад дэмжих портал сайт”-д мэдээлэл оруулах чиг баримтлалыг боловсруулж нийтлэх [ХЗЯ] «17»
- “Миний дугаар” портал сайт зэргийг ашиглан мэдээллийг түргэн авах болон захиалгат төрлийн мэдээлэл болон цахим шуудангын контент мэдээлэл түгээх систем турших [ХЗЯ] «18»
- Гадаад иргэдийг хүлээн авах орчин бүрдүүлэх үйл ажиллагаанд олгох татаасны журмыг өөрчлөх зэргээр нэгдсэн байдлаар зөвлөгөө өгөхөд зориулсан цонхтой болгох ажлыг эрчимжүүлэх [ХЗЯ] «20»
- Олон хэлээр орчуулах технологийг сайжруулж бодит хэрэгцээний түвшинд “синхрон орчуулга” хийлгэх боломжтой болгох, автомат орчуулга хийлгэх голлох хэлийг нийт 21 хүртэл нэмэгдүүлэх ажил [ЕРЯ] «23»
- Гадаад иргэдэд дэмжлэг үзүүлдэг орон нутгийн хамаа бүхий байгууллагууд нэгдэж зөвлөгөө өгөхөд зориулсан хамтарсан уулзалт зэргийг зохион байгуулах [ХЗЯ] «27»
- Хялбаршуулсан япон хэлийг түгээн дэлгэрүүлэх зорилготой сургалт зэргийг зохион байгуулах [ХЗЯ] [БШЯ] «31» «32»

3 Амьдралын үе шат, мөчлөгт тохирсон дэмжлэг туслалцаа үзүүлэх

- Хүүхэд өсгөж буй гэр бүлүүдийг хоорондоо танилцуулж, хүүхэд өсгөх явцын хүндрэл, сэтгэл зовнилын талаар хэлэлцэх талбараар хангах зэрэг бүс нутгийн хүүхэд өсгөх цэгийг бэлдэх үйл ажиллагаа [Хүүхэд гэр бүлийн хэлтэс] «33»
- Иргэний үндсэн бүртгэлийн систем болон сургуулийн насны хүүхдийн бүртгэлийн системийг уялдуулснаар гадаад хүүхдүүдийн сургалтын талаар нэгдсэн байдлаар мэдээлэл олж хяналт тавих боломжийг нэмэгдүүлэх [БШЯ] «36»
- Мужийн ахлах сургуульд элсэх шалгалтыг зохион байгуулах явцад гадаад хүүхдүүдэд зориулан тусгай орон тоог бий болгож, шалгалт өгөх үед хэрэгтэй тусламж үзүүлэх ажлыг эрчимжүүлэх [БШЯ] «47»
- Япон хэлний ганцаарчилсан сургалтыг ахлах сургуулийн сургалтын хөтөлбөрт нэмж оруулах тогтолцоог нэвтрүүлэх [БШЯ] «49»
- “Hello Work” хөдөлмөрийн бирж дэх гадаад иргэдийн буланд зөвлөгөө өгөх мэргэжилтэн, орчуулагчийг ажиллуулан тохиромжтой хөдөлмөр эрхлэлтийн тухай зөвлөгөө өгөх, Гадаад хүмүүсийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх мэдлэг заавар чиглэл өгөх [ЭМХЯ] «57»
- Гадаад оюутанууд япон компанид ажилд орохыг нэмэгдүүлэх арга боловсруулан, үр дүнтэй холбоо бий болгон, шаардлагатай арга хэмжээ авах, дотоодын ажилд орох хувийг нэмэгдүүлэх систем бий болгох [БШЯ] «59»
- Гадаад оршин суугчдад зориулж тэдний япон хэлний чадварыг харгалзсан мэргэжил олгох сургалт зохион байгуулах [ЭМХЯ] «61»
- Тэтгэврийн тогтолцооны тухай мэдээлэл түгээх, зар сурталчлах ажлыг үргэлжлүүлэн төгөлдөржүүлэх [ЭМХЯ] «63»
- “Гадаадын оршин суугчдын тухай үндсэн судалгаа” зэрэг аргаар бодит байдлыг илрүүлэх [ХЗЯ] «66»

4 Хамтын нийгмийн суурь тогтцыг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ

- “Гадаад иргэний хамтын оролцооны талаар сурталчлах сар” (түр зуурын нэр) хөдөлгөөнийг шинээр эхлүүлж, төрөл бүрээр сурталчлах арга хэмжээ зохион байгуулах [ХЗЯ] «67» «68»
- Сургууль дээр харийн ёс заншил соёлыг ойлгох, олон орны соёлууд зэрэгцэн орших гэсэн бодлогын дагуу боловсрол олголтыг улам хүртээмжтэй, чанартай болгох [БШЯ] «71»
- Гадаад оршин суугчийн тухай статистик мэдээллийг ашиглаж, иргэншил, Японд оршин суух зөвшөөрлийн ангилал, эрхлэх ажлын чиглэл зэрэг гадаад иргэдийн аж амьдралын байдалтай танилцах боломжтой статистик мэдээллийг агуулсан шинэ хүснэгтийг боловсруулж нийтлэх [ХЗЯ] «74»
- Гадаад ажилтны хөдөлмөрийн нөхцөл зэрэг ажил эрхлүүлэх байдлыг хянах, гадаадын хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн шилжилт өөрчлөлт зэрэг бодит байдалтай танилцах статистикийн судалгааг хийх [ЭМХЯ] «75»
- Хувийн хэвшлийн дэмжигч байгууллагуудаар гадаад иргэдэд “Out Reach” буюу хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлсэн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн туршилтын ажил хэрэгжүүлэх [ХЗЯ] «80»
- Гадаадын иргэн, харьяатын газарт гадаад оршин суугчдын тухай хэрэгтэй мэдээллийг нэгдсэн байдлаар авах чадвартай бүтцийг бүрдүүлэх талаар судлах [ХЗЯ] «82»
- Хувийн дугаарын карт болон гадаад оршин суугчийн картыг нэгтгэснээр ашиглахад хялбар болгох [ХЗЯ] «85»
- Гадаад хүмүүсийг дэмжидэг хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн өндөр чанартай дэмжигч ажилтныг итгэмжлэх тогтолцооны тухай судлах [ХЗЯ] «86»

4. Ажлаа эрчимжүүлэх нөхцөл бүрдүүлэх

- ◆ Төлөвлөгөөний хугацааг 2026 он хүртэл гэж үзнэ.
- ◆ Эрдэмтэн мэргэдийн саналыг харгалзан үзэн ахиц дэвшил гарсан эсэхийг жил бүр хянаж, шаардлага гарвал арга хэмжээнд өөрчлөлт оруулна.
- ◆ Тухайн жилд хэрэгжүүлэх ёстой зүйлийг ерөнхийлсөн арга хэмжээнд тодорхой заана.

5 2023 оны санхүүгийн жилд хянан шалгах ажлууд

Мэргэжилтнүүдийн онцолсон гол санал зөвлөгөөнүүд

- Жил бүр хэрэгжүүлж буй арга хэмжээний тухайд нэг талыг барьсан хүснэгтээр илэрхийлсэн нь бодит нөхцөл байдлыг мэдэх боломжгүй болгосон байна.
- Гарааны үзүүлэлтүүд (KPI үзүүлэлтүүд) эсвэл үр дүнгийн үзүүлэлтүүдийг ашиглах нь үйл ажиллагааны үр дүнг ойлгоход хялбар болгодог.
- KPI үзүүлэлтүүдийн тоон баримт нь тухайн хугацаан дахь өөрчлөлтийг ойлгоход нь чухал үзүүлэлт тул төлөвлөгөөний зураглалыг шийдэхээс өмнө тоон баримтанд тулгуурлан нягт судлахыг хүсч байна.
- Шинээр хэрэгжүүлэх бодлого боловсруулахад KPI үзүүлэлтийг тодруулах нь хүнд боловч KPI үзүүлэлтүүдийг ашиглахаар шийдсэн л бол тодорхой ойлгомжтой байлгах шаардлагатай.
- Бусад бодлогын арга хэмжээний талаар санал зөвлөгөөнүүд

Дахин хянаж сайжруулах гол арга хэмжээнүүд

Үйл ажиллагааны хүснэгтийг дахин хянах 70 санал

KPI үзүүлэлтүүдийг дахин хянах 28 санал

Шинэ болон хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг дахин хянах 13 санал